



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Даваа гараг

| | |
|--|------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2-3 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 4-18 |

| | |
|--|-----|
| 1. Түр хорооны тогтоолын төсөл /Хянан шалгагч, шинжээч нарын ажиллах хугацааг сунгах тухай/ | 4-8 |
|--|-----|

| | |
|-----------------|------|
| 2. Бусад | 8-18 |
|-----------------|------|

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
Хянан шалгах түр хороо /Хөгжлийн банкны асуудлаар/-ны
2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 24 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар.

Нэг.Түр хорооны тогтоолын төсөл /Хянан шалгагч, шинжээч нарын ажиллах хугацааг сунгах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Ганбат нар үг хэлэв.

Б.Энхбаяр: “Хянан шалгагч, шинжээч нарын ажиллах хугацааг сунгах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Бусад

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх

Г.Золжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр 2023 оны 01 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос зохион байгуулах нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын зохион байгуулалтын асуудлаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Д.Батлут, Д.Ганбат, Б.Бат-Эрдэнэ, Н.Ганибал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 51 минут үргэлжилж, 12 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 15 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ
ТҮР ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 24 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгуур бүхий Түр хорооны 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Нэг.Түр хорооны тогтоолын төсөл /Хянан шалгагч, шинжээч нарын ажиллах хугацааг сунгах тухай/

Түр хорооны шинжээч нарын ажиллах хугацааг сунгах тухай тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Та бүхэн тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байвал нэрсээ өгнө үү. Нэрс алга байна. Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байвал нэрсээ өгнө үү. Б.Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн үгээ хэлье.

Хурлын ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, миний бие хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулья.

Нэгдүгээрт, “Түр хорооны шинжээч нарын ажиллах хугацааг сунгах тухай” тогтоолын төсөл.

Хоёрт, Бусад гэсэн асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орё.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би хоёр зүйл хэлье.

Нэгдүгээрт, манай Түр хороо ажлаа сайн явуулж байгаа.

Тэгэхээр Хөгжлийн банкны асуудалтай холбоотой ажил маань ямар түвшинд явж байна вэ. Тэр талаар Түр хорооны дарга нэг товч мэдээлэл бидэнд өгвөл бололцоо байна уу гэж.

Хоёрдугаарт, манай Түр хорооны хугацаа чинь 4 сарын эхээр дуусах байх. Тэгээд энэ хугацаандаа ажлаа дарга бүрэлдэхүүнийхээ хамт үүнийгээ нэг эцсийг нь дуусгаад ажлаа цэгцэлж авах

шаардлага байна гэж би гишүүний хувьд ингэж үзээд байна.

Олон удаа нааш цаашаа болоод. Ялангуяа ингээд нэг асуудал яригддаг. Тэгээд сүүлдээ чимээгүй болоод. Тэгээд сүүлд нь ямар нэгэн үр дүн гардаггүй. Улсад учирсан хохирлыг нь төлүүлж чаддаггүй. Дээрээс нь хулгай, луйвартай холбоотой улсуудтай хариуцлага тооцож чаддаггүй асуудлууд байгаа.

Тийм учраас би энэ зүйлийг хэлэх гэж байгаа юм.

Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад би өмнө нь Түр хорооны хурал дээр хэлж байсан. Энэ шинжээч, бусад ажиллаж байгаа хүмүүсийг үндсэн ажлаас нь чөлөөлөөд энд татаж ажиллуулж байгаа. Энэ ажиллаж байгаа мэргэжлийн өндөр түвшний хүмүүсийн ажиллаж байгаа ажлын нөхцөл байдал, цалин хангамж, бусад талаас нь ажиллах бололцоогоор нь хангаж өгөх ийм шийдвэрүүд гарсан. Тэр хэвийн явж байна уу.

Хамгийн гол анхааруулж хэлэх юм бол тэр үндсэн ажлынх нь газар өмнө нь гарч байсан. Бид Их Хурлаас ажлын хэсэг байгуулаад ажиллаж байхад ч гарч байсан. Энэ ажиллаж байгаа хүмүүст янз бүрийн дарамт, ил далд хэлбэрээр хясан боогдуулсан, дарамталсан, айлган сүрдүүлсэн янз бүрийн ийм асуудлууд гарч ирж байсан.

Тийм учраас өөрийнх нь байгууллагын үндсэн ажлынх нь байрыг баталгаатай байлгах тал дээр нь бид анхаарах ёстой. Энэ зүйлийг би хэлье. Баярлалаа.

Б.Энхбаяр: Б.Бат-Эрдэнэ гишүүн чухал асуудал хөндөж ярьж байгаа.

Нэгдүгээрт, хяналт шалгалтын ажил маань ерөнхийдөө үргэлжилж байгаа. Өнгөрсөн оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын тогтоолоор Хянан шалгах түр хороо байгуулагдсан.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зааснаар зургаан сарын хугацаагаар ажиллана. Нэг удаа зургаан сарын хугацаагаар сунгана гэсэн ийм хуулийн заалттай. Үүний дагуу зургаан сарын хугацаагаар сунгагдаад ингээд Түр хорооны маань ажиллаж дуусах цаад хугацаа энэ оны 04 дүгээр сарын 15 байгаа.

04 дүгээр сарын 15-нд Түр хороо тайлангаа Улсын Их Хуралд албан ёсоор тавьж дуусгах хуулийн хугацаатай. Энэ дагуу бид өмнөх хурлаараа нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын товыг тогтоосон.

Ирэх долоо хоногийн нэг дэх өдрөөс буюу 2023 оны 01 сарын 16-наас 01 сарын 20-ны хооронд Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлсэн 3.5 их наяд төгрөгийн зээлтэй холбогдох асуудлыг зээл тус бүрээр хэлэлцэж нотлох баримтыг шинжлэн судалж гэрчүүдийг асууна. Өмнөх хурлаар бид 166 хүнийг гэрчээр дуудсан.

Мөн энэ тогтоолтой хамт нэмж дуудах шаардлагатай гэрчийн асуудал хяналт шалгалтын явцад үүсэх юм бол нэмж дуудах эрхийг Түр хорооны дарга надад олгосон байгаа. Үүний дагуу өнгөрсөн оны сүүл энэ оны эхээр миний бие хянаж шалгах шинжээч нартайгаа хамт вакуумжиж хяналт шалгалтын

урьдчилсан нөхцөл байдлуудыг нэг бүрчлэн ярьж явж байгаа.

Ер нь хагас, бүтэн сайнгүй л өчигдөр уржигдар гээд л ерөөсөө тасралтгүй ажиллаж байгаа.

Ингээд хяналт шалгалтын тухай хуульд зааснаар Түр хорооны сонсгол эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ гэсэн хуулийн заалтын дагуу өнөөдөр өглөө 11.00 цагаас Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Ж.Бат-Эрдэнэ нарын хамт ирэх долоо хоногт зохион байгуулагдах хурлын тов, хэлэлцэх асуудлын талаар олон нийтэд хэвлэлийн бага хурал хийж мэдээлсэн байгаа.

Хоёр дахь сонсгол 2023 оны 02 дугаар сарын 06-наас 10-ны өдрүүдэд зохион байгуулагдахаар байгаа. Энд Хөгжлийн банкны эх үүсвэрээр улсын төсвөөс эргэн төлөх нэ нөхцөлтэй хөрөнгө оруулалтын шинж чанартай 355 төсөл, арга хэмжээний зээлийн ашиглалт, зарцуулалт, үр дүнг сонсохоор байгаа. Энэ асуудал бас урьд урьдын шалгалтуудаар нэг их орж байгаагүй. Урьд нь энэ шалгалт нэг их хийгдэж байгаагүй асуудал байгаа. Үүнийг бас нэг бүрчлэн ярихаар байгаа.

Гурав дахь асуудал нь 2023 оны 03 сарын 13-наас 03 сарын 17-ны өдрүүдэд Хөгжлийн банкнаас эх үүсвэрээр арилжааны банкнуудаар дамжуулан олгосон 2542 төсөл, хөтөлбөрийн зээлийн зарцуулалт, ашиглалтыг ярих байгаа. Энэ 2542 төсөл, арга хэмжээ рүү урьд нь ямар ч шалгалт хийгдэж байгаагүй гэсэн үг.

Бид энд нэг л эрх ашгийн үүднээс аливаа улс төржилгүйгээр асуудлыг

Тэгэхээр олон нийт манай Түр хороог өмнө нь ярьсан юмнуудаа л яриад л болох гэж байгаа сонсгол гэсэн ойлголт байгаа.

Энэ их өөр сонсголууд явагдана. Яагаад гэхээр хоёр дахь, гурав дахь сонсгол үндсэндээ урьд нь шалгалт орж байгаагүй ийм асуудал руу нэлээн лавхан орж байгаа. Тийм.

Ингээд хянан шалгагчийн хараат бус ажиллах нөхцөлийг хангах дээр асуудал тавьсан. Миний хувьд ч гэсэн ажиллах шинжээч нарын төсөв, санхүүгийн асуудлыг шийдэж өгөх асуудлаар нэлээн чанга дуугарсан.

Тэгээд холбогдох зүйлүүд ярьсан. Улсын Их Хурлын дарга бас нэлээн сайн дэмжиж, Төсвийн байнгын хороон дарга дэмжиж Түр хороон дээр 100 сая төгрөгийн 2023 онд төсөв батлуулсан. Тийм.

Тэгээд баталсан төсвийнхөө хүрээнд бид ажиллах боломж үүсэж үр дүн гарч байгаа. Үр дүн гарч байгаа. Ийм зүйлийг Б.Бат-Эрдэнэ гишүүний хөндөж тавьсан асуудал дотор багтааж хэлье.

Нэг асуудал дээр. Яг энэ Түр хорооны бүрэлдэхүүнээрээ бид эцсийнхээ үр дүнг үзэх ёстой гэдэг Б.Бат-Эрдэнэ гишүүнтэй би санал нэг байгаа. 4 сард дуусна. Бид үүний эцсийн ард нэг төгрөг болгоны араас гарч энд олонхын гишүүд, цөөнхийн гишүүд манай бүх төлөөллүүд орсон.

хариуцаж үүний ард гарч чадна байх гэсэн ийм бүр бүрэн дүүрэн итгэлтэй байгаа.

Сонсголууд Монголын Үндэсний олон нийтийн телевизээр шууд дамжигдана. Тав хоногийн туршид өглөөнөөс үдэш хүртэл шууд дамжигдана. Тийм.

Тэгэхээр Үндэсний олон нийтийн телевизийн шууд дамжуулалтын явуулын станцыг байршуулж, тийм зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөж байгаа гэдгийг эрхэм гишүүддээ хэлье.

Нэмж Д.Батлут Түр хорооны гишүүн ирсэн байна. Н.Ганибал гишүүн ирсэн байна. Д.Ганбат гишүүн ирсэн байна. Л.Мөнхбаатар дарга ирсэн байна гэдгийг ирцэд. Одоо бараг 100 хувийн ирцтэй Түр хороо хуралдаж байна.

Д.Ганбат дарга үг хэлье. Д.Ганбат гишүүн. Асуулт тасалсан.

Д.Ганбат: 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын орхигдоод байсан, байхгүй байсныг хянан шалгах энэ үйл ажиллагааг боломжтой болгосон л доо.

Тэгээд Улсын Их Хурал бол хууль тогтоохоос гадна хуулийн хэрэгжилтэд араас нь явж байх ёстой. Хуулийн хэрэгжилтийг шаардаж байх ёстой ийм л байгууллага л даа.

Тэгээд ард түмний мандаттай ийм улсууд. Энэ Хянан шалгах түр хороо анх удаагаа Монгол Улсад байгуулагдсан Хяналт шалгалтын түр хороо. Тэгээд энэ загвар хороо яаж ажиллаж байгаа вэ гэдгээсээ цааш цаашдын тэр хороодын хянан шалгах үйл ажиллагаа шалтгаалах юм.

Тэгээд хоёр дахь Түр хорооны даргаар манай Б.Энхбаяр гишүүн ажиллаж байна. Өмнө нь Ж.Сүхбаатар гишүүн ажиллаж байгаад дэвшээд маш чухал түгжрэлийн сайд гэдэг ажил л хийгээд явж байгаа байх.

Тэгээд өмнө нь ЖДҮ-гийн луйвар байсан. 60 тэрбумын луйвар байсан. Ингээд Хөгжлийн банкны луйвар дээр Хянан шалгах түр хороо байгуулаад ажиллаж байхад бас нүүрсний хулгай луйвар илэрч байна. Ингээд ар араасаа шилээ харсан луйврууд гараад байдаг.

Эндээс бас нэг юм үгүйсгэгдээд байгаа юм. Хэн ч ёс зүйн хариуцлага хүлээдэггүй. Хэн ч түдгэлзэж байгаад шалгуулдаггүй. Нэр ус нь гараад л ингээд алга болчихдог.

Тэгээд энэ дээр бас л нэг ярьж байгаад л ингээд алга болчихдог ийм зүйл байж болохгүй юм л даа. Тэгээд гэмт хэрэгтнүүд, энэ хулгайчууд аягүй ял завшиж байна. Зүгээр мөнгөө төлчихсөн гээд маш хөнгөлөлттэй зээлийг маш урт хугацаанд авчхаад ямар ч бүтээн босгосон юм байхгүй ингээд өнгөрчихсөн. Тэгээд ард түмнийг болохоор нөгөө Энэтхэгийн бүр дээр үеийн кастын системд оруулчихсан.

Ийм юм хэзээ байхгүй болох юм, яах юм. Энэ Хянан шалгалтын түр хороо ардчилсан улс орнуудад байна л даа. Тэр нөхдүүд тэр Түр хороон дээрээсээ гавлуулаад л явж байна шүү дээ. Энэ шударга ёс, энэ хууль үйлчлэх энэ зүйлийг шахаж шаардаад байгаа юм.

Сүүлийн бараг 10, 20 жил Увсын гаралтай нөхдүүд Хууль зүйн яамыг, Хууль зүйн салбарыг толгойлж сүлжээ үүсгэсэн. Маш их мөнгийг цавчихсан. Шантааж хийж авсан. Одоо тэрийг мөнгө

угааж байгаа хэсэг нь ч гэсэн энэ дотор байгаа.

Тэгээд энэ ордон дотор хүн үхэж байсан. Хүн алж байсан. Тэр гэмт хэрэг нь ил гардаггүй. Ийм юмыг бид нар халхалж хаацайлаад явж байна. Нөгөө талаар гурван шатны шүүхийн шийдвэрээ гаргадаг. Тэр шүүхийн шийдвэр юу ч биш. Хэрэгждэггүй. Тэр С.Зоригийг алсан хүмүүсийг илрүүлээ л гэдэг. Үгүй болоод л явчихдаг. Гурван шатны шүүхийн шийдвэр гаргасан л байдаг.

Ийм юмнууд чинь энэ хуулийг хэрэгжүүлдэггүй. Энэ Түр хороо нь зөв зүйтэй ажилладаггүй энэ зүйлээс болж байна. Тэгээд бид нар олон улсын аудит оруулмаар байгаа юм. Энэ Хөгжлийн банк дээрээ.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэлж дууслаа.

Та бүхэнд би Түр хорооны тогтоолын төслийг уншиж сонордуулъя.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоол.

“Хянан шалгах түр хорооны шинжээчийн ажиллах хугацааг сунгах тухай”. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 34.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсэг, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Монгол Улсын Их 15 хүртэл. Дуусах хугацаа хүртэл хугацаагаар сунгаж байгаа.

Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоол, “Хянан шалгах түр хорооны шинжээч томилох тухай” 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоол, “Шинжээчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос ТОГТООХ нь:

1.Монголбанкны ахлах хянан шалгагч Одсүрэнгийн Оргилмаа, Монголбанкны хянан шалгагч Очирбатын Лхагвадорж, Үндэсний Аудитын газрын ахлах аудитор Баттулгын Эрдэнэбат, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Батмөнхийн Хишигтогтох нарыг Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий Түр хорооны шинжээчээр ажиллах хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл сунгасугай.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг баталъя гэдэг саналыг томъёоллоор санал хураалт явуулъя.

90.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Өнөөдрөөс 04 сарын

Хоёр.Бусад

Бусад асуудлын хүрээнд Та бүхэн нэг асуудлыг танилцуулъя гэж бодож байна.

Хяналт шалгалтын ажил маань үргэлжилж байна. Энэ 04 сарын 15 хүртэл л үргэлжилж явагдана. Хамгийн эхний сонсгол маань Хөгжлийн банкнаас шууд зээл авсан нийт 77 зээлийн асуудлыг ярих. Шууд зээлтэй холбоотой асуудлыг ярина.

Нийтдээ 77 зээлийн асуудал байна. Хянаж шалгагч шинжээч нарын урьдчилсан дүгнэлтээр 18 зээл нь хэвийн байна буюу энэ зээлүүд дээр эхний сонсгол дээр гэрчээр дуудах ийм асуудал байхгүй. Зээл олголт хуулийн дагуу. Зээл олголт төлбөр юм нь хийгдсэн. Зарим нь яг анх байгуулсан гэрээнийхээ дагуу хийгдэж байгаа. Зарцуулалтын хувьд зориулалтын дагуу зарцуулсан ийм хэвийн зээлүүд байна гэдэг ийм асуудлыг танилцуулсан.

Тийм учраас Түр хороон даргын хувьд нэгэнт хэвийн гэж байгаа энэ зээлүүдийг нөгөө гэрч дуудах сонсгол дээр заавал танилцах шаардлагагүй. Одоо цаг хугацаа хэмнэвэл ямар вэ гэсэн ийм саналтай байгаа юм. Миний хувьд. Яагаад гэхээр 77-гоос энэ 18-ыг хасах юм бол нийтдээ 59 зээлийн асуудлыг бид ирэх долоо хоногт эхлэх сонсгол дээр ярих нь байна. Энэ маань дунджаар 11-ээс 12 зээлийн асуудлыг нэг өдөр ярина гэсэн үг.

Ний нуугүй хэлэхэд 59 зээл дээр гарч ирж байгаа асуудлуудын цар хүрээ, яригдах асуудлыг авч үзэхэд нэг зээл дээр хамгийн багадаа 5, хамгийн ихдээ 10 орчим хүнийг гэрчээр асуух ийм шаардлага үүсэж байна. Өөрөөр хэлбэл бид 166 хүнийг дуудсан. Ингээд нэмж дуудах асуудал үүсвэл миний бие дуудна гээд тооцоод үзэхэд одоо ирэх долоо хоногийн сонсгол дээр доор хаяж 300 гаруй. 300-аас 500 хүн гэрчээр дуудагдах нөхцөл байдал үүсэж байна. Одоогоор.

Ингээд танилцуулах асуудлууд нотлох баримтын цар хүрээг авч үзэхээр маш хугацаа зарах. Бид Түр хорооныхоо сонсголыг өглөө 09.00 цагт эхэлье гэж байгаа юм.

Өглөө 09.00 цагт эхлээд нэг өдөрт 11 зээл, 12 зээлийн асуудал ярина гэж бодоход нэг зээлийг нэг цагт ярихад бид нар ороод 7 цагт дуусаад байгаа байхгүй юу. Тэгэхдээ ундны завсарлагагүйгээр явахад.

Тэгэхээр одоо миний урьдчилж танилцсан байдлаас үзэхэд доор хаяж нэг зээл дээр зарим зээлүүд бүр хагас өдөр болж болзошгүй ийм байдал байна. Маш их зөрчил, маш их олон хүн асуух.

Тэгэхээр бидний үргэлжлэх хугацаа маань долоо хоногтоо багтахгүй байх өндөр эрсдэлтэй байна шүү гэдгийг би урьдчилж гишүүддээ хэлэх гэж байна. Хэрвээ ингэж амжиж байхгүй нөхцөл байдал үүсэх юм бол бид 20-нд биш үргэлжлүүлж сунгаад ирэх долоо хоногт нь дахиж үргэлжилж хуралдах ийм шаардлага нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Тийм учраас гишүүд маань энэ нөхцөл байдлыг тооцож ажлын асуудлыг, ялангуяа тойрогтоо ажиллах, сонгогчидтойгоо уулзах гээд олон асуудлууд манай гишүүдэд байгаа.

Тэгэхээр ийм асуудал үүсэж болзошгүй байна шүү гэдгийг би хэлж ажлын зохион байгуулалтаа хангаж байгаарай гэдгийг нэгдүгээрт урьдчилж хэлэх гэж байна.

Хоёрдугаарт, ийм нөхцөл байдлууд байгаа учраас хэвийн байгаа зээлүүдийн асуудлыг хэвийн гэдгийг нь

танилцуулаад тэгээд жоохон цаг хожиж нөгөө зөрчилтэй асуудалтай байгаа зээлүүд дээр илүү имэрч, илүү нухацтай ярих цаг хугацаагаа бас гаргавал ямар вэ гэдэг ийм саналтай байгаа. Тэгээд хэвийн гэж байгаа 18 зээлийг би уншаад Та бүхэнд нэг сонгочихъё гэж бодож байна.

Нэгдүгээрт, Багануур хувьцаат компани.

Хоёрдугаарт, Дулааны цахилгаан станц IV төрийн өмчит хувьцаат компани.

Гуравт, Зорчигч тээвэр III орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, МИАТ төрийн өмчийн хувьцаат компани, Бид майнинг ХХК, Говь хувьцаат компани, Гоёо ХХК, Дархан минж ХХК, Дорнын Цас ХХК, Мавангүй ХХК, МАК Цемент ХХК, Монватт ХХК, Мөнпеллетс ХХК, Пи Ай Эм Эм ХХК, Сор кашмер ХХК, Ти Жи Вай ХХК, Хамтын эх булаг ХХК, Монголын Газрын Тос Боловсруулах үйлдвэр ХХК гэсэн ийм зээлүүдийг одоо манай хянан шалгагчдын зүгээс хэвийн юм байна гэдэг асуудлыг танилцуулсан байгаа.

Хэрвээ Та бүхэн маань дэмжвэл эдгээр зээлийн асуудлыг гэрч дуудахгүйгээр ийм зээл олгочихсон гэдэг байдлаар танилцагдаад гэрч дуудахгүйгээр явчхаж болж байна уу гэдэг ийм асуудлыг би оруулж байгаа юм. Яагаад гэхээр би энэ Түр хороон даргын хувьд би өөрөө дангаараа шийдэх нь зохистой биш асуудал. Ямрыг нь дуудаад ямрыг нь дууддаггүй юм бэ, яагаад хэвийн биш гэж үзсэн юм бэ гэдэг асуудал дараа нь гарна.

Тийм учраас би бусад асуудлын хүрээнд Түр хорооны гишүүдэд энэ асуудлыг танилцуулж байна.

Энэ асуудалтай холбоотойгоор асуулт, үг цуг явчихъя. Тэгэх үү. Асуулт, үгтэй гишүүд нэрсээ өгнө үү. Б.Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Т.Доржханд гишүүн асуултаа асууя.

Т.Доржханд: Баярлалаа.

Тэгэхээр парламентын түүхэнд хяналт тавьж болдог юм байна. Тэгээд хулгай хийчихээд, эсвэл хууль бусаар элдэв төрлийн сан, мөн төрийн өмчийн байгууллагуудаас мөнгө аваад тэгээд сайхан түүгээрээ ингээд ямар нэгэн хариуцлага хүлээгээд явж болдоггүй юм байна гэдэг жишгийг л тогтоох ёстой л доо.

Тэгэхээр энэ бол анхны Түр хороо. Тэгээд анх удаагаа бид нар нотлох баримт болон гэрчээс байцаалт гэдэг юм уу, эсвэл гэрчээс мэдээллийг нь авах гэж байна. Парламентын түүхэнд анх удаагаа.

Тэгэхээр Нэгдүгээрт, шударга байх ёстой байх. Нэг. Тэгээд хоёрдугаарт, зарчмын хувьд бид өмнө нь ярьсан байгаа. Асуудалтай байж болно. Тэгэхдээ асуудалтай гээд нөгөө нийгмийн шахалтад ийм юм уу, хуулийн байгууллагын шахалтаас хамаараад зээлээ төлчихсөн нөхдүүд байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр тэр хүмүүсийг ядаж зээлээ зориулалтын дагуу ашигласан байна уу, аль эсвэл бас ёс зүйн хариуцлага хүлээх үү, үгүй юу гэдэг агуулгаар нь ижил түвшинд хандаж энэ дээр гэрчээр дуудаж авах хэрэгтэй л гэсэн энэ байр суурь хэвээрээ байгаа.

Харин сая Түр хорооны даргын хэлдэг хэвийн төлөлтэй явж байгаа. Ялангуяа хувийн секторын ийм зээлүүдийг бид нар энэ дээр гэрчээр дуудаад байх шаардлага байхгүй байх.

Харин төрийн өмчийн оролцоотой компаниудын нэрс дуудаад байна. Үнэхээр шаардлага байхгүй гэх юм бол магадгүй тэр нь яг зориулалтынхаа дагуу мөнгө нь төлөгдөөд явсан гэх юм болж байна.

Ер нь миний зарчмын хувьд төрийн өмчийн компани зээл аваад цалингаа тавиад явдаг. Тэгсэн мөртлөө цаанаа бүгдээрээ алдагдалтай байдаг. Тэгээд үр дүнд нь төр өөрөө ингээд хохироод байдаг. Энэ системийг л бид байхгүй болгох ёстой л доо. Тэгээд тэр агуулгаараа үнэхээр хэвийн төлөлтэй явж байгаа, ямар ч асуудал байхгүй гэх юм бол хүлээж авч болж байна. Зүгээр төрийн өмчийн компани юм чинь дээ тэгээд болчих байлгүй дээ гэсэн агуулгаар хэрвээ хандаж байгаа бол тэгэх нь буруу байх.

Тийм болохоор илүү төрийн өмчийн компаниудыг оруулж ирж яриулаад, тэгээд цаашид ингэж төрийн өмчийн компаниудыг санхүүгийн хувьд сахилга батгүй байдлыг нь өөгшүүлдэг. Мөнгө хэрэгтэй гэсэн үед нь мөнгийг нь шууд төрөөс шийдэж өгдөг. Ногоон гэрлээр шийдэж өгдөг. Хувийн сектортой өрсөлддөг энэ нэг буруу зүйлийг нь бид хязгаарлах учиртай л гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Д.Батлут гишүүн үгээ хэлье. Асуулт, үг.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Түр хорооны даргын санал болгож байгаа асуудалтай танилцлаа. Төр өмчийн компаниуд дунд л ер нь маш их асуудлууд байгаад байгаа. Тэнд юу байна хулгай болж байна.

Төрийн өмч үнэгүйдэж байгаа. мөн төрийн өмчийг далимдуулсан. тэнд төрийн өмчийг ашигласан бизнесийн бүлэглэлүүдийн бас үйл ажиллагаа маш их явж явагдаж байгаа.

Тэгэхээр таны дурдсан энэ компаниуд дотор төрийн өмчийн компаниуд бас нэлээн хэд дурдагдлаа л даа. Миний хувьд харин магадгүй нэлээн сайн төрийн өмчийн компаниудыг шалгах ёстой болов уу гэж харж байгаа юм. Энэ ямар учиртай зээл авсан юм. Тэр зээлийнх нь өгөөж нь ямар байгаа юм бэ гээд олон талаас нь харах хэрэгтэй байх.

Тухайлах юм бол саяын дурдсан нэр дотор IV дулааны станцтай холбоотой мэдээлэл орж ирэх гэж байх шиг байна. Анх энэ Хөгжлийн банкттай холбоотой асуудал орж ирж байхад эргэлзээтэй зээл гэдэг дотор Дулааны цахилгаан станц IV төрийн өмчит компани явж байсан санагдаад байгаа юм. Би тэгж харж байсан.

Хэрвээ тийм байгаа бол яагаад энэ зээл нь эргэлзээтэй байснаа одоо ингээд хэвийн төлөлтэй болоод эхэлчихэв гээд асуудлууд дагуулж эхэлнэ л дээ. Тэгэхээр энэ тал дээр бас нэг хариулт өгөөч ээ гэж.

Тэгэхээр төрийн өмчийн компаниуд тэр зээлээ хэрхэн өгөөжтэй ашиглаж байгаа вэ гэдэг талаас, ямар үр өгөөж өгч байгаа вэ гэдэг талаас нь бид анхаарч үзэх хэрэгтэй. Тэгэхгүйгээр тэр зээл аваад мөнгө угаагаад орхидог тийм хэлбэр болгож хүмүүст үлдээж болохгүй. Яг үнэндээ болохгүй байгаа зүйлүүд чинь

хаана болж байна төрийн өмчит компани дээр л болж байгаа. Өөрийн биш, дандаа хүнийрхүү сэтгэлээр ханддаг. Энэ зээл дээр ч гэсэн тийм дүр зургууд зөндөө л байгаа. Ганц нэгээс нь уншиж байхад тиймэрхүү дүр зураг ажиглагдаж байсан учраас би энэ асуултыг тавьж байгаа юм. Баярлалаа.

Б.Энхбаяр: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Сая Т.Доржханд гишүүн Д.Батлут гишүүн хоёр энэ төрийн өмчийн компаниудын зээлийн асуудлыг ярья гэдэг ийм саналыг тавьж байна.

Түр хорооны хянан шалгах шинжээчдийн зүгээс энэ зээлүүд хэвийн гэж надад танилцуулсан. Энэ зээлүүдийн зарцуулалттай холбоотой би дэлгэрэнгүй танилцуулгыг хянан шалгагч шинжээч нараас сонсоогүй. Хэвийн, асуудалгүй гэдэг танилцуулгыг л надад хэлсэн учраас цаашаа дэлгэрүүлж ороогүй байгаа гэсэн үг.

Эрхэм гишүүд санал гаргаж байгаа учраас зарчмын дагуу энэ 4 төрийн өмчийн компаниуд. Багануур, Дулааны цахилгаан станц IV, МИАТ, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр гэсэн 4 төрийн өмчийн компанийн асуудал байна.

Энэ 4-ийг дэлгэрэнгүй танилцах ийм асуудалд оруулж зарцуулалтыг нь танилцъя. Өөрөөр хэлбэл эндээс хасаад одоо нийтдээ 55 зээлийг сонсъё гэж байсан бол одоо 63 зээлийг сонсох болж байна. Гишүүдийн саналыг хүлээж авч байна. Миний хувьд.

Д.Ганбат гишүүн асуулт, үг хэлье.

Д.Ганбат: Би юу яаж байгаа юм. Саяын миний өмнө гишүүд хэлсэн юм шиг байна. Тэр төрийн өмчтэй компаниудыг оруулж ирэх нь зөв байх аа. Сонсох нь ч зөв байх. Түр хорооны дарга ч бас Түр хорооныхоо гишүүдийн саналыг нь авч байгаа нь зөв гэж үзэж байна. Тийм. Тэгээд би тэр олон улсын аудит л оруулахгүй бол энэ Хөгжлийн банкны юм чинь хагас дутуу гарна шүү.

Тэгээд зүгээр л нэг хэлэлцээд ярилцаад л өнгөрдөг. Нэг иймэрхүү юм өнгөрчихлөө гэсэн тийм юм үлдээж болохгүй.

Одоо бид нарын өмнөх асуудал дээр бид баахан тэр шинжээч, хянан шалгаж, аудиторын ажиллах хугацааг нь 4 сараар сунгачихлаа шүү дээ. Тэр хүмүүс маань тухайн үедээ бас нөгөө л Хөгжлийн банкны юмыг хянах, барих ёстой л улсууд байсан байна шүү дээ. Тэр хийж байсан ажлуудыг нь харж байхад.

Тэгээд энэ улс чинь бүгдээрээ төрийн албан хаагчид байна. Шинжээчид энэ тэр чинь. Энэ улсууд тэр гаднын ямар нэгэн хараат бусаар энэ асуудлыг оруулж ирээд ингэж барина гэсэн юм байхгүй байх гэж бодож байна.

Тэгэхээр мэдээж хэрэг тэр 4 компанийг оруулах ёстой. Тухайлбал, газрын тос боловсруулах үйлдвэр гэхэд л бид аль 2022, 2023 онд л газрын тостой болчихно гэсэн. Энэ одоо байхгүй л байгаа байхгүй юу. Хэд хэдэн удаа амалж, хэд хэдэн удаа тууз хайчилж байсан. Тийм. Одоо Улаанбаатар төмөр зам гэхэд л нэг мэргэжилтэн ч юм уу, тэр хавийн л хүнээс арван хэдэн тэрбум төгрөг гарч байна шүү дээ. Гудсан доороос нь. Тийм. Тэгэхэд нөгөө Улаанбаатар төмөр зам компани нь 2020, 2021 онд 37 тэрбумын алдагдалтай

ажилласан гэсэн ийм үзүүлэлттэй байна. Гэх мэтчилэнгийн зүйлүүд байна.

Тэгээд бид одоо бас энэ сонсголыг хийгээд, Түр хороо ажиллуулаад энэ арга хэмжээг бид авч чадах уу, үгүй юу. Бас. Тэр хууль эрх зүйн орчин байна уу, үгүй юу. Энэ хууль эрх зүйн орчин, Хууль зүйн салбар чинь үндсэндээ дампуурчхаад байгаа юм биш биз дээ. Энэ шүүх тогтолцоо энэ тэр чинь.

Бид сайжруулаад байна гэдэг. Үнэндээ тийм юм алга байна шүү дээ. Хэн гэдэг хүнээс болж яаж байгаад ийм болгосон юм. Яагаад хууль зүйн салбарыг зориуд ийм байлгаад байсан юм. Тэр шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар энэ тэр чинь сүлжээнд орчихсон юм биш үү. Үүнийг хэн ийм болгосон юм. Тэндээс маш их мөнгө завшсан нөхдүүд нэгийгээ Улсын Их Хурлын гишүүн болгочхоод л мөнгө угаалгаад л байж байна шүү дээ.

Одоо 01 сарын 01-нээс нөгөө үндэслэлгүйгээр хөрөнгөжих тэр юм чинь хэрэгжиж байгаа юу, үгүй юу. Тэрийгээ зориуд төрийн мэдээ сэтгүүл дээр хэвлүүлэхгүй бариад байна гэсэн. Тэр үнэн юм уу, худлаа юм уу.

Одоо 01 сар гараад 15 хоночихлоо. Өнөөдөр хэн шалгуулж байна. Хууль яаж хэрэгжиж байна. Хууль яаж дээдэлж ажиллаж байна. Хууль эрх зүйн орчин байдаг. Тэр хуулийг хэрэгжүүлдэг тэр хүмүүс чинь ажиллахгүй учраас л бид энд ийм юм яриад сууж байна шүү дээ.

Тэгээд нөгөө хүмүүс нь бүгд мөнгөө төлчихсөн л бол ял завшсан маягтай ингээд үлдэж байгаа. Нэг ийм тал руугаа л явдаг. Түүнд нь баярлаад сүйд болоод л. Өчнөөн хөнгөлөлттэй зээл, өчнөөн үйлдвэр завод барина гээд

Монголын ард түмний боломжийг хулгайлаад авчихсан, идчихсэн, уучихсан. Бараг л энэ Хяналтын түр хороон дээр л итгэл найдвар үлдэж байна шүү. Яаж ажиллах вэ, яах вэ ийх вэ гээд.

Би хууль эрх зүйн орчныг нь тийм сайн гэж бодохгүй байна. Энэ хяналтын Түр хорооны ажиллахыг. Нэлээн хэл ам хийлгэж байж хэдэн төгрөгийн төсөв тавиулах шиг боллоо. Үүнийг тавьж өгөхгүйгээр их хааж боолоо шүү дээ. Тийм. Гайгүй хуульч хоёр гишүүн.../минут дуусав/

Б.Энхбаяр: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Нээлттэй нотлох баримтын сонсгол дээр манай Түр хорооны гишүүд гэрчээс асууна. Бие биеэсээ асуухгүй шүү дээ. Д.Ганбат дарга аа. Яагаад гэхээр бид тэнд нэг нь дарга, нэг нь цэрэг гэдэг тийм юм байхгүй. Яг адил нотлох баримттай танилцана. Бүгд адилхан эрхтэй ийм байдлаар болно.

Тийм учраас зүгээр хоосон ярьдаг. Эд нар ярьж л байдаг юм. Тэгээд юу ч илрүүлсэн юм, илрүүлсэнд нь хариуцлага тооцсон нь хаа ч байгаа гэдэг энэ ард түмний цөхрөл, итгэл алдрал энэ юман дээр бидний Түр хорооны энэ нотлох баримтыг шинжлэх хяналтын сонсгол цэг тавих байх гэж би бодож байгаа юм.

Бид ард түмний төлөөллийн дээд байгууллага. Үүнээс цааш хандах газар байхгүй. Бид тэр итгэл найдварын эцсийн цэг. Энэ итгэл найдварыг төлөөлж бид байгаа учраас энэ итгэл найдвар дээр бид гишүүн болгон хариуцлага үүрч байгаа юм.

Тийм учраас Түр хорооны сонсголд манай Түр хорооны гишүүд

зуун хувийн ирцтэй байх үүрэгтэй. Маш хариуцлагатай оролцох, ажил хэрэгч оролцох ийм үүрэг хүлээж байгаа. Хяналт шалгалтын сонголт дээр Та бүхний гар дээр маш их хэмжээний нотлох баримтад танилцагдсан. Маш их хэмжээний. Урьд нь Хөгжлийн банкны холбоотой яригдаж байснаас маш өөр асуудлууд энд яригдана гэдгийг би урьдчилаад хэлчихье. Маш олон улс төрчдийн асуудал яригдана. Маш олон хүмүүс. Нам үл харгалзаж яригдана.

Тийм учраас энэ асуудалд бид аль нэг намаас нэр дэвшиж сонгогдсон гишүүд биш. Бид Монголын ард түмнээс сонгогдсон ард түмний төлөөлөгч гэдэг энэ шалгалтаа өгнө. Шалгалтаа өгч таарна.

Тийм учраас энэ оролцоон дээрээ та бүгд нотлогдоно. Таны ярьж байгаа нэг асуудал дээр би санал нэг байгаа. Тэр нь ер нь энэ Хөгжлийн банктай холбогдсон асуудлууд дээр урьд нь хууль хяналтын байгууллагууд юу хийж байсан юм. Хууль хяналтын байгууллагуудтай холбоотой асуудлууд яригдана. Би урьдчилаад хэлчихье.

Тийм учраас энэ нэлээн тийм өргөн цар хүрээтэй. Тэгэхдээ зөвхөн сураг ажгаар биш дандаа нотлох баримтаар яригдах асуудлууд гарна. Нэг зүйлийг гишүүддээ харин шууд хэлчихье. Энэ сонголт дээр зөвхөн нотлох баримтын хүрээнд л асууна шүү. Тийм.

Та бүхний гарт тараагдсан хяналт шалгалтын хүрээнд тогтоогдсон нотлох баримт яриад байна шүү дээ. Нотлох баримт байхгүй юу. Гарцаагүй нотлох баримтаар тэр хүний асуудал яригдана. Сураг ажгаар огт асуудал яригдахгүй.

Та өөрөө Түр хорооны гишүүн шүү дээ. Тэрийгээ Та тэр үед нь улс төрч юм уу, Их Хурлын гишүүн хашиж байгаа, хашиж байсан ч гэдэг юм уу ийм хүмүүстэй холбоотой асуудал үүсэхэд бүгд Түр хорооны гишүүд адил эрхтэй. Миний хувьд бүгдийг нь оруулна. Нотлох баримтаар. Нотлох баримтаар оруулна. Дандаа нотлох баримтууд яригдана гэдгийг л би гишүүдэд хариуцлагатайгаар хэлье.

Б.Бат-Эрдэнэ гишүүн асуулт, үгээ хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би хоёр зүйл асуугаад орхиё.

Нэгдүгээрт, түрүүн Түр хорооны дарга манай Түр хороо, одоо энэ сонголт, энэ гарах дүгнэлт, энэ гэрчийг дуудаж асуух энэ асуудал бол бүхэлдээ ер нь итгэл найдварын эцсийн цэг гэж хэллээ.

Тэгээд энэ дээр санал нэг байгаа. Түр хороог анх байгуулах, хэнээр ахлуулах вэ тухай асуудал яригдаж байхад Их Хурлын урдаа барьдаг хуульчдын нэг, бас итгэл даах ийм хүн гэж үзэж Жамьянхорлоогийн Сүхбаатараар ахлуулж байсан. Одоо ахалж байгаа Б.Энхбаяр гишүүн өмнө нь Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байхдаа энэ Хөгжлийн банкиг шалгах Ажлын хэсгийг ахалж байсан хүн.

Би түрүүн хэлэхдээ ч хэлээд байгаа нь яг энэ Түр хорооны даргатайгаа энд байгаа гишүүд байна. Манай Т.Доржханд гишүүн Сангийн яаманд олон жил ажилласан туршлагатай хүн. Ж.Бат-Эрдэнэ гишүүн. Дээрээс нь манай Д.Ганбат Хуулийн хороон даргаар ажиллаж байсан Их Хуралд. Манай Э.Батшугар, Н.Ганибал гээд. Ингээд Д.Батлут байна.

Тэгэхээр зэрэг түрүүн Түр хорооны дарга хэлээд байна. Яг нотлох баримт дээр тулгуурлаж энэ Хяналт шалгалтын хууль батлагдсантай холбоотой хяналт шалгалтын бүрэн эрхийн Их Хурал хэрэгжүүлэх ийм бололцоо гарч ирж байгаа юм гэж.

Ийм зүйлийг хэлээд хоёр асуух гээд байгаа юм бол нэгдүгээрт, энэ ТУЗ-ийн гишүүд байгаа. ТУЗ-ийн гишүүд. Тийм ээ. Энэ ТУЗ-ийн гишүүдэд хариуцлага тооцох, энэ хүмүүсийн сонсгол дээр гэрчээр дуудах. Эндээс тодорхой асуудал гарах байх гэж бодож байгаа. Үнэхээр бид Хөгжлийн банкны ажлын хэсэг дээр ажиллаж байхад туйлын хариуцлагагүй ажилласан. Энэ ТУЗ-ийн гишүүд. Хөгжлийн банкны ТУЗ-ийн гишүүдийг л ярьж байна шүү дээ. Тийм зүйл харагддаг. Одоо саналаа өгөхдөө жишээлэх юм бол дандаа эчнээгээр хуралдаад ихэнх нь эчнээгээр хуралдаад тэгээд санал нь зүгээр дэмжсэн, дэмжээгүй гэдэг тухай асуудал биш. Татгалзах зүйл байхгүй гээд саналаа өгчихсөн байх жишээтэй. Ийм асуудлууд байдаг юм.

Ер нь цаашдаа энэ төрийн өмчийн нийтийн өмчийг захиран зарцуулж байгаа, нийтийн олон нийтийг төлөөлж эрх үүргээ хэрэгжүүлж байгаа төрийн өмчийн компаниудыг ил тод нээлттэй болгох. Тэнд ТУЗ-ийн гишүүдийг нь хариуцлагажуулах. Цаашлах юм бол иргэдийн оролцоо хяналтад байлгах. Тэр хараат бус гишүүд гээд хүмүүс байдаг. Тэр хүмүүс бас ялгаа байхгүй тун хариуцлагагүй ажиллаж байсан ийм юм нийтлэгээр харагдаад байдаг л даа. Энэ дээр анхаарах хэрэгтэй байгаа юм.

Хоёрдугаарт, Хөгжлийн банкны зээлийн асуудал чинь 2012-ос 2016 онд.

Ямар нэгэн улс төржиж, намчирхаж байгаа асуудал биш шүү. 2012-ос 2016 онд тэр гаднын менежментийн багийг хөөж явуулаад л. Тэгээд л тэндээс ерөөсөө бүлэг фракцаараа л үндсэндээ шийдвэртэй шийдвэргүй хуваагаад авчихсан ийм зүйлүүд гаргадаг. Том том дүнгээр.

Энэ дээр мэдээж манай Түр хороо, энэ экспертүүд ажлын хэсэг ажиллаж байгаа байх гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, тэр төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлчихсэн. Хөгжлийн банкнаас. Тэр санхүүжилт нь яг тухайн зах зээлийнхээ үнээр үнэлгээ, өртөг нь ямар байгаа юм. Тэр хэрэгжсэн төслийн чанар байдал нь ямар байгаа юм. Ийм юман дээр бас анхаарлаа хандуулах ёстой байх. Тэгэхгүй бол энэ Хөгжлийн банкнаас гарсан зээлийн чинь ихэнх нь төсвийн хөрөнгө оруулалт гээд хаачихсан ийм зүйл ажлын хэсэг дээр ажиллаж байхад харагдаж байсан шүү гэдэг ийм хоёр асуулт, санал байна.

Б.Энхбаяр: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой асуудлыг бас нэг бүрчлэн шалгаж байгаа. Тэр оролцоо юмнуудыг. Ер нь зээл тус болгон дээр дандаа нотлох баримтаар танилцуулахаар бэлтгэж байгаа. Тэр дээр янз янзын асуудлууд гарч ирж байгаа. Эрсдэлтэй гээд дүгнэлт гарчхаад байхад ТУЗ-даа танилцуулахдаа тэрийг эрсдэлтэй гэдгийг нь дарж байгаад танилцуулчихсан асуудлууд бас байна. Тэр дээр ТУЗ-ын гишүүдийг буруутгаад байх боломж байхгүй гэж бодож байгаа. Яагаад гэхээр эрсдэлтэй гэдэг юмыг нуун дарагдуулсан үйлдэл бол тэр тухайн зээлийн мэргэжилтэн, тэр дарга нарын

асуудал. Гэм буруугийн асуудал байхгүй юу.

Ингээд ТУЗ-аа хуурсан гэсэн үг. ТУЗ-ийн гишүүдээ хуурсан нөхцөл байдал тогтоогдож байгаа. Бас. Мөн таны хэлсэнчлэн тийм оролцоо, гэм буруугийн асуудал ч гэсэн бас нотлох баримттайгаар яригдана.

Тэгэхээр энэ зээл болгон дээрээ өөр юм билээ. Зээл болгон дээрээ өөр нөхцөл байдлууд нотлох баримтаар дэлгэрэнгүй хүн болгоны гэм буруугийн асуудал яригдана гэж үзэж байгаа.

Ер нь энэ дээр хариуцлагатай хандах учиртай. Яагаад гэхээр хүний гэм буруугийн асуудал ярьж байгаа учраас цаана нь бас хуулийн хариуцлага яригдах эсэх үр дагавар руу хөтлөх учраас бид маш хариуцлагатай хандах. Сураг ажгаар юм уу, хар таамгаар юм уу хүнийг буруутгах эсвэл яллах ийм байр суурь барьж болохгүй.

Буруутгах нотлох баримтыг ч тэр, түүнийг цагаатгах нотлох баримтыг ч тэр эн тэнцүү авч үзэж ярих ийм зарчмыг баримтална гэдгийг танд хэлье.

Н.Ганибал гишүүн асуулт, үгээ хэлье.

Н.Ганибал: Энэ гэхдээ маш их хүлээлт дунд бид бүхэн сонсголоо зохион байгуулна.

Тэгээд анхаарах юмнууд маш их байдаг юм байна. Эхлээд энэ ширээ сандлаа, танхимаа яаж зохион байгуулахаас эхлээд л.

Тэгээд Түр хорооны гишүүдийн оролцоог зуун хувь хангуулах, мэдээллээр хангах асуудал маш чухал юм

байна. Харилцан адилгүй мэдээллээр асуудалд хандах нь эргээд магадгүй нөгөө намчирхсан байдал харагдуулдаг ч юм уу. Таны хэлээд байгаа тэр ард түмний төлөөлөгч биш намын төлөөлөгч болж харагдах энэ аюул гарч ирнэ.

Өнөөдрийн ч гэсэн асуудал дээр анх удаа сонсож байгаа компаниудын нэрийг сонсонгуутаа ямар нэгэн яагаад хасагдаж байгаа гэдэг юуг нь ганц өгүүлбэрээр сонсонгуутаа за тэгье хасья гээд хэлэх нь эргээд хардалт төрүүлнэ. Бид өнөөдөр наад мэдээллийг чинь анх удаа л сонсож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ өнөөдрийн оруулж ирж байгаа асуудлыг Түр хороогоороо асуудлыг бид нар шийдмээргүй байна. Үүнийгээ яг л тэр ард түмний сонсголын тэр цаг дээр нь шалтгаануудыг нэг бүрчлэн хэлээд ингээд асуудлыг нь шийдээд явах юм бол үнэхээр нээлттэй асуудлыг шийдэж байгаа бол ер нь зээл болгоны ард хулгай байна. Ямар нэгэн албан тушаалын асуудал байна гэж ойлгох нь өөрөө бас өрөөсгөл. Гэхдээ энэ ийм учраас зөв. Үүнийг заавал шалгаад байх шаардлагагүй гэдгийг нь нэг бүрчлэн бас ярих нь зөв байх.

Тэгэхээр зээл болгон дээр нотлох баримттай ярьж байгаа бол бүгдийг нь л ярих хэрэгтэй. Түүнээс магадгүй өнөөдрийн нэрсүүдийг чинь ингээд гүйцэж сайн сонссон ч үгүй. Одоо маш олон нэрүүдийг ингээд давхцуулаад хэлэхээр нэгэн дээр бодож байх хооронд нөгөөдөх нь сонсогдоод өнгөрчихлөө л дөө.

Тэгэхээр энэ дээр эсрэг байр суурьтай байна. Түр хорооны гишүүдэд өгөх шинжээчдийн дүгнэлтийг бид эртхэн авмаар байна. Тэгэхгүй болохоор харилцан адилгүй мэдээлэлтэй байгаад

асуудалд хандахаар эргээд хартал төрөх, мэдээллийн дутмагаас болоод бие бие рүүгээ дайрах ийм асуудал гарах магадлалтай.

Тэгэхээр энэ дээрээ манай дарга бас анхаараач ээ.

За за өөр одоо тэгээд яг тэр сонсголын цаг хугацааны үед маш олон асуудлууд гарч ирэх байх. Нотлох баримт маань бараг хэдэн арван өөр кэйсүүд явж ирнэ шүү дээ. Тийм ээ. Тэр болгон дээр бидний бас ингээд тодорхой аль нь албан тушаалын давуулан ашигласан юм. Аль нь хариуцлагагүй байдал гаргасан юм. Аль нь тэр зээлийг. Янз бүрийн л асуудлууд гарна шүү дээ. Тийм үү. Бүх асуудлууд гурав, дөрөвхөн хуваагдахгүй. Авлига, албан тушаалтай холбогдож байгаа гээд.

Тэгэхээр энэ болгон дээр нь ангилж нийгэмд зөв ойлголт өгөх тал дээр хэдүүлээ бас ажиллахгүй бол бүгд рүү нь, бүх зээлдэгч нар луу хар будаг цацчихвал буцаагаад нөгөө өндийж явсан том олон бизнесийг, магадгүй хэвийн үйл ажиллагаатай бизнесийн байгууллагуудаа бид нар бас харлуулах, муухай харагдуулах ийм байдал харагдах байх.

Тэгэхээр мэдээллээр л маш сайн хангаж өгөөд энэ хүрээндээ ярья гэдэг тэр саяын яриад байгаа зарчим дээрээ тулгуурлаад явбал амжилттай болох байх гэж бодож байна.

Б.Энхбаяр: Н.Ганибал гишүүний асуултад хариулъя. Н.Ганибал гишүүний зарчмын байр суурьтай миний хувьд санал нэг байгаа.

Ер нь ингэж тогтоё. Сая гишүүд. Миний хувьд ч гэсэн яг энэ асуудлаар манай шинжээч хянан шалгагч нар

хэвийн ийм асуудлууд байгаа гэдэг юмтай бас танилцаагүй байгаа. Би яагаад хэвийн гэдэгтэй нь бас танилцаагүй гэсэн үг.

Тийм учраас ерөнхийдөө энэ бүх зээлээ хэвийн гэж байгаа. Эднийг бас нэг товч танилцуулаад танилцуулаад явчихъя. Надад юу гэж танилцуулсан гэхээр энэ дээр гэрч дуудах шаардлагагүй гэж байгаа юм. Одоо зөрчил илрээгүй учраас хэн нэгнийг асуугаад тодруулаад байх шаардлагагүй гэдгийг танилцуулж байгаа. Яагаад гэхээр би өнөөдөр бүх гэрчүүдийнхээ нэрсийг ажлын албандаа өгөх ёстой. Дуудах хүмүүсийг.

Тийм учраас ийм асуудлыг би бусад асуудалд яриад байгаа юм. Тийм учраас энэ ямар зээл, ямар хугацаатай, хэзээ авсан юм, яагаад хэвийн гэж үзэж байгаа тэр дүгнэлтүүдийг ер нь бүгдийг нь сонсгол дээрээ сонсьё. Тийм ээ. Бүгдийг нь сонсьё.

Гэрч бол энэ дээр би дуудахгүй нь байна шүү л гэж хэлээд байгаа байхгүй юу. Би энэ зээлүүд дээр гэрч дуудахгүй нь байна шүү гэж. Танилцуулгыг сонсьё. Танилцуулгаас мэдээж гишүүд тухайн тухайн үед асуух тэр юм бол нээлттэй.

Нэг зүйлийг ер нь гишүүд маань энэ зүйлийг бас ойлгоод авчхаарай. Энэ танилцуулгууд хийгдэж байгаа тохиолдолд ер нь Түр хорооны сонсгол бол ирэх долоо хоногтоо багтахгүй гэдэг маш ойлгомжтой болж байгаа шүү.

Тийм учраас түүний дараагийн долоо хоног руу сунгаж сонсгол маань үргэлжлэх нь байна шүү. Ер нь хоёр долоо хоног эхний сонсгол маань үргэлжлэх нь байна. Хоёр дахь сонсгол маань долоо хоног, гурав дахь сонсгол маань долоо хоног.

Ер нь бүтэн сар ямар ч байсан. Сарын турш сонсгол хийгдэх нь байна шүү гэдэг ийм бэлтгэлтэйгээр ажлаа зохицуулж байгаарай. Ажлаа зохицуулж байгаарай гэдгийг хэлчихье.

Миний урьдчилж тооцож харж байгаагаар хоёр дахь сонсгол, гурав дахь сонсгол хоёр бас ажлын тав хоногт багтаааргүй харагдаад байгаа юм шүү. Урьдчилж.

Тэгэхээр энэ бол ер нь 30-аас 45 хоногийн сонсгол хийх. Монголын түүхэнд байгаагүй ийм юм болох гээд байгаа шүү гэдгийг гишүүддээ хэлээд тэгээд ажлаа сайн зохицуулаарай гэдгийг Та бүхэндээ хэлье.

Ингээд асуулт хариулж дууслаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан учраас Түр хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

Хуралдаан 51 минут үргэлжилж, 15 цаг 16 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД